

**“НАЙМАН АРСЛАНТ” ХЭМЭЭХ ГҮР ДУУНЫ
ӨВӨРЛӨГЧ НУТАГ ДАХЬ ХЭДЭН ХУВИЛБАРЫН ТУХАЙ**

Б. Хишигсүх (МУИС) дэд профессор

Б. Хас-Эрдэнэ (докторант)

“Найман арслант” хэмээх энэхүү дууны талаар тусгайлан дагнасан судалгаа өнөө хэр цөөн байна. Судлаач У. Загдсүрэн 1975 онд Улаанбаатар хотноо хэвлүүлсэн “Монгол дууны судлалын товч тойм” гэдэг номондоо “Найман арслант” хэмээх гүр дууны дөрвөн өөр хувилбарыг хэвлүүлж нийтийн хүртээл болгосон байдаг.

Монголын бурханы шашины нэрт зүтгэлтэн Лувсанноровшаравын мэндэлсний 310 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд судлаач Н. Нарангэрэл “Чин сүжигт Номун ханы өв соёл” гэдэг номондоо “Найман арслант” хэмээх дууны шүлгийн сийрүүлэг, аяс нотны бичлэгийг хамтруулан хэвлүүлжээ. Дээрхи хувилбаруудыг ажиглахад шад, бадаг нь нэлээд зөрөөтэй байгаа хэдий ч ерөнхий утга, агуулга нь адил байгаагийн учир нь халхын Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын “Найман арслант” хэмээх нэг эхт гүр дуу болох нь нэн тодорхой байна. Халхын Чин сүжигт Номун хан Лувсанноровшарав нь бурханы шашины үнэнч зүтгэлтэн төдийгүй, зон олныг өвчин эмгэг, гай зовлонгоос гэтэлгэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж явсныг нь Өндөр гэгээн Богд Жэбзундамба хутагт гүнээ сайшааж түүнд “Халхын эрдэнэ ноён цорж” хэмээх цол соёрхож хутагтын зиндаанд өргөмжилсөн байна.

Хожим нь эрдэм боловсрол, чадвар, хичээл зүтгэлээрээ Манжийн Энх-Амгалан (Кан Ши), Найралт Төв, Түтээмэл Элбэгт нарын зэрэг гурван үеийн хааны хүндэтгэлийг олж улмаар Ордос долоон хошууны засаг ноёд нэгэн дуугаар Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравыг бишрэн сүсэглэж орон нутагтаан залж ном тавиулах болсон байлаа.

Түүний нэр нөлөө улам гүн хүндлэлийг олсоор Тэнгэр Тэтгэгчийн 22-р (1755) онд Тэнгэр Тэтгэгч эзэн хааны насан өлзийг бататгахын учраар хурал ном хуруулах, сүсэгтэн олны хүслийг биелүүлэх гүн их сэтгэлийн үүднээс “Билигийг бадруулагч шар Зуу” хэмээх дөчин таван лам бүхий бэсрэгхэн хийдийг байгуулах зөвшөөрлийг олж авч чадсан юм.

Тухайн үед Халх Монголд цагийн байдал ороо бусгаа болсны улмаас шашин номыг сурталчлан дэлгэрүүлэх суурин газрын сүм хийд сүйрэлд орж, бурхан ном

хөнөөлд өртөж, бүр хуучны дуу дуулах хүртэл цаазлан хоригдсон байлаа. Энэ бүхний уршгаар Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын “Найман арслант” хэмээх гүр дууг аялах хүн нэн ховордсон билээ.

Өвөрлөгч нутгийн Ордос Их-Зуу, Урад, Алагшаа зэрэг газарт уг дууны хувилбарыг эдүгээ ч гэсэн найр хуримд дуулсаар байгаа нь ихээхэн олзуурхууштай санагдаж байна. Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын “Найман арслант” хэмээх гүр дууг Өвөрлөгч нутагт анх өөрчлөн дуулж дэлгэрүүлсэн хүний нэг нь Улаанцавын чуулганы Урадын баруун гүнгийн хошууны Мэргэн хийдийн III дүрийн гэгээн 1717-1766 оны хооронд аж төрж, бүтээж туурвиж явсан Лувсанданбийжалсан юм.

Баримт, мэдээллийг үндэслэвэл Лувсанданбийжалсан багаасаа Баруун Да багш Шидэндамбийжалсан цорж, Эрдэнэ гүүш, Өглөггүндалай, Равжамба, Билгүүндалай, гүүш Номундалай зэрэг олон эрдэмтэн багш нараар бурхан шашины эши онол, төвд, нанхиад, самгарди хэлийг заалгаж хичээн суралцсан бичгийн мэргэн байлаа. Тэрбээр гахай жил буюу 1731 онд 4 сард Утай тийш Сэрүүн уулнаа одож нанхиад, төвд, монгол, манж хэлийг гарамгай эзэмшсэн нэгэн алдартай эрдэмтэн (хуушанг) багшийг шүтэж бурханы номын нанхиад орчуулгын эрдэмд хичээнгүйлэн суралцжээ.

Улаан луу жил 1736 онд Цастын орноо одож төвд, балба, энэтхэг, уйгур хэлний үсэг бичгийн орчуулгын эрдэмд 5 жил гүнзгийрэн суралцаад равжамба цол хүртсэн ажээ. Тэнгэр Тэтгэгчийн 5-р (1740) онд Рашилхамбуу хийдэд хүрч Ванчин Богд, Дэма гэгээн нараас гэлэн санваарыг хүртэж улмаар бурхан шашины төв байсан Наландара хийдэд хүрч долоон жилийн турш их, бага арван ухаанд суралцаж номын дээд “бандида” цолыг хамгаалжээ.

Мэргэн гэгээн Лувсанданбийжалсан, Мэргэн хийдийн лам Согодай нарын халамж анхаарал, сан жасын элбэг дэлбэг хөрөнгө мөнгөөр бага балчир наснаасаан олон эрдэмтэн багшийг шүтэн, бурхан шашины ариун дагшин газарт шамдан суралцсанаар билиг нээж гучин нас хүрэхийн үес эрдмийн оройгүйд боловсорсон нэгэн болсон байлаа.

Тэр цагт Мэргэн хийдээс холгүй, Хатан голын цаад эрэгт орших Бэхэт туулайн ам хэмээх газарт өөрөөс нь арван зургаан нас ах халхын Эрдэнэ ноён цорж Лувсанноровшарав (1701-1768) ламхай, Чин сүжигт Номун ханы цолыг хараахан хүртээгүй байсан авч Шар зуугийн суурийг хэдийнээ тавьсан, номын цуу нь алдаршаад байсан байна. Мэргэн гэгээн Лувсанданбийжалсан Лувсанноровшаравын зохиосон гүр дууг ихэд бишрэн сонирхож чөмгийг нь барьж байгаад охор (богино) авсаархан бадаг болгож өөрчлөн дуулсан нь түүний гүр дуунд хийсэн шинэчлэл болсон ажээ.

Уг дуу тухайн цагтаа шар, хар олны дунд түгээмэл дэлгэрч бүр найр хуримд заавал дуулагддаг ардач чанар бүхий “Найман арслант тавцан” хэмээх дуу болж тархсан байна. “Найман арслант тавцан” хэмээх уг дуу нь:

01 Найман арслант тавцангийн дээр

Навчит зандан мод бурханы чимэг

02 Дөрвөн арслант тавцангийн дээр

Дэгтэрт зандан мод бурханы чимэг

03 Хаврын гурван сар хавартаан шуургантай

Хаваржаагаар сууна гэгч манай нутаг хол

04 Зуны гурван сар зундаа халуун шүү

Зуслангаар сууна гэгч манай нутаг сайхан

05 Намрын гурван сар намартаан сайхан шүү

Намаржаагаар сууна гэгч манай нутаг сайхан

06 Өвлийн гурван сар өвөлдөөн хүйтэн шүү

Өвөлжөөндөө сууна гэгч манай нутаг хол: хэмээн дуулагдаж байна.

Чин сүжигт Номун ханы хийд дээр 7-18 нас хүртэл суралцаж байгаад ороо бусгаа цаг төрийн эрхээр буцаж ирсэн Шар зуугийн хамгийн сүүлчийн баруун гэгээн Довдонпэлжээгийн дурдатгалыг үндэслэвэл, Лувсанноровшарав цагаан нохой жил буюу Найралт Төвийн 8-р (1730) онд Их зуугийн чуулганы Ордосын баруун гарын хойт хошууны Хангин хошууны Бэхэт туулайн аманд жижиг сүмийг байгуулан шавь элсүүлж эхэлсэн гэдэг.

Судлаач Н. Нарангэрэл Найралт Төвийн 10-р онд 1732 онд уг сүмийг байгуулсан гэж тэмдэглэжээ. /7/ Дээрхи мэдээллийг үндэслэвэл Лувсанноровшарав Найралт Төвийн 8-р онд сүм байгуулсангүй төдийгүй тухайн цагт Их зуугийн чуулганы бэйл, бэйс нарын урилгаар Ордос зүүн гарын хойт хошуу Далад, Ордос баруун гарын хойт хошуу Хангины зах нутагтай нийлж бүхий Хатан гол дагуух нутат нэгэнтээ ирчихсэн байсан нь нэн тодорхой байна. Түүний гар доор шавилж байсан нөлөө бүхий шавийн нэг нь Ордос баруун гарын өмнөд хошууны Ганжуур Номин хийд болон Үүшин Зуугийн шавь Шаравёндон болно. Шаравёндон долоон наснаасаа багш хэмээн шүтэж ном эрдэмд суралцаад есөн насан дээрээ мацаг санваар авч 13-40 нас хүртэл Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын гар доор шавилж 30 гаруй жил болсон байна. Хожмоо тэрээр Баруун Зуугийн газар олон Богд нарын айлдсан ном судрыг Уйзан төвдийн орон, Бээжинээс залж ирсэн бөгөөд ном эрдмээрээ гаргуун нэгэн тул “билигт хамба” хэмээх цолыг хүртэж Ганжуур Номун хийд Үүшин Зуугийн цогчин дацангийн ширээт ламын суудалд саатсан түүхтэй ажээ.

Ордос баруун гарын өмнөд хошуунд билигт хамба Шаравёндонтой адил Чин сүжигт Номун ханыг биширч, шашин номыг дэлгэрүүлэх үйл хэрэгт бүхнээ зориулсан нэгэн бол туслагч тайж Ганжуурын 2-р хөвгүүн Тодой бөлгөө. Тэрээр Тэнгэр Тэтгэгчийн 53-р (1788) онд эцгийн ор залгамжилж туслагч болжээ. Тодой туслагч цогийн буянаар машинд өндөр, мэдэл оюун олноос хэтэрхий, шашиныг өргөмжлөн амьтныг асрах итгэл төгөлдөр тул бэйс Баяндай эхлэн хошууны олон бүгдээр биширч “Сэцэн зоригт Дугар мэргэн ахай ноён” хэмээн өргөмжилжээ. /9/

Хожим нь тэрээр Урадын мэргэн гэгээний өөрчилж зохиосон “Найман арслант тавцан” гэх дууны хувилбарыг баяжуулж “Найман гун арслан” гэдэг нэрээр Ордост дэлгэрүүлсэн байв. Тодой туслагч Цагаан хэрэмийн зах дахь Муу тохой гэдэг газарт байгуулсан Банчин сүм гэдэг тахилын орондоон Чингис хааны хөрөг шүтээнийг бүтээлгэн түүний нөхөд сэлт нарыг тахиж шүтэх тахилга тайлга, өчиг дуудлагыг зохиолгох, жич шинсэ Богд Лувсандаржаа гэгээнийг Урад нутагтаан залж ном тавиулж, дүйнхэрийн хурал Чойдог хурах жаяг зарчимыг зохиолгох зорилгоор цаст Төвдийн оронд мөргөл үйлдэхийн тулд Сайшаал Ерөөлтийн 16-р (1811) онд хаан эзнээс эш зарлигийг олгоод хаврын сүүл сарын өлзийт өдөр хатан Балжид, хөвгүүн Гончигжав, дагалт мэйрэн Мянгалжав, Далайт, хөтөч Сэнгэ, Цолмон, Батмөнх, Бадарша, Сандалай зэрэг хүмүүийг дагуулан морджээ. Тэд эн тэргүүнд Гүмбүм хийдэд хүрч, гэгээн лам нар, Их алтан суварга тэргүүтэй дээд шүтээнд мянган тахил өргөн мөргөж, дараа нь Богд лам нарт өргөл барьж, олон хутагтан хуврагт манз, зэд өргөн хэрэг зоригоон даатгажээ. Зуны дунд сар цааш морилон Дүйнхор хийд дээр хүрч, шинсэ Богд Лувсандаржаа гэгээнд учран мөргөж, нууц тарни очир хөлгөний абшигийг авсны дараа Богд гэгээнтнийг өөрийн хошууны Ганжуур Номун хийд дээр залж, ерөнхий бус номын рашаан хүртэх хүсэлтэй байгаагаан дурдтган айлдсанд хожим морилж хүрсүгэй! хэмээн амласан байжээ. /10/

Эрх Дугар мэргэн ахай ноён Тодой туслагч, Гүмбүм хийдийн сойвон Нямаа лугаа хамт үргэлжлэн аяарласаар Гүн эрэг хэмээх газар хүрч, Цагаан Номун хан болон Гонлун хийдийн сүмбэ хутагт, Дүйнхэр хийдийн Манзушири хутагт нарт учран мөргөөд тэдгээр Богд нарын хамт таван зуун цэргээр хамгаалуулан аяарласаар Тэмээн Хүзүү хэмээх газар хүрч, Мичин Бумрайн урд харш хэмээх асаар өндөр цаст уулыг холоос бараалан мөргөөд замаан элээх зуур олон сангасваа нар хорт салхин босгож, догшин бороо оруулж бэртүүлжээ. Цуг явсан богд нар салхи, бороог хариулж явсаар Эүйшин хэмээх газар хүрэхэд, олон дээрэм угтан ирсэнд Куамдуа тайж, тансаг Нансу нар очиж, уулзсанд дээрмийн түрүү: “Танай хүмүн олон, үр хүчин их, бид хорлол үл үйлдмүй.” хэмээн тангараглаад тарж явжээ. Ийнхүү Бэрх уулыг давж үргэлжлэн аяарласаар намрын сүүл сар Лхас хотноо хүрчээ. Тэнд хүрээд хамгийг айлдагч есдүгээр дүрийн Очирдара далай лам Лувсан-жамсу богдод бараалхаж үг бишрэл баясгаланг олоод Галт Тивийн гэгээн, Рарин Номун хан, дээд богд Димү хутагт хийгээд мэргэн шидтэн Жамъяншадавын гэгээн тэргүүтэн лүгээ учирч мөргөөд номын рашаан ба адистэдийг хүртэж, маш их баясал болсон ажээ. /11/

Ордос баруун гарын өмнө; хошууны мөргөлчид тус жилийн өвлийн тэргүүн сар, Далай ламын сангаас хайрласан улаагаар Раашлхамбуу хийд тийш үргэлжлэн морилж, хамгийг айлдагч 7-дугаар дүрийн Ванчин Богд Лувсанданбийням гэгээнд бараалхав. Ванчин Богд тэдэнд мутрын адис хүртээх зуур “Газрын холоос чин сүсэглэн зорьж ирсэн урьдын ерөөл барилдлагат эрхэм өглөгийн эзэн мөн болой.” хэмээн айлдан сайшаагаад Тодой туслагчид барын арьсан дэвсгэр хайрлаж, доорд газар орны ахуй ёсон ба замын аян турш ямар явсан, унаа бие сэлт амар хүрч ирсэн зэрэг олон зүйлийг асуун тохинуулжээ. Үүний хамт өөрийн зоог цай ба замбаа гурил тос боорцог, элдэв жимс сэлтийг хүртээснээр барахгүй шадар шавь нараан томилон элбэг дэлбэг идээний зүйлсийг бууж суусан сан дор өдөр бүр хүргээж хайрласаар байжээ. /12/

Тэндээс Эрх Дугар мэргэн ахай ноёнтон Раашлхамбуу хийдийн их хурал дор Ванчин Богдыг залж эрдэнийн мандал гурван шүтээн ба элдэв зүйлийн тахилын эд, хаан төрийн долоон эрдэнэ өлзийт найман эд хийгээд алт мөнгөн эрдэнэсийн зүйлс, хив торго magna түшлэг зэрэг өргөлийн зүйлсийг мянган лангаар бэлтгэн өргөн хүндэлсэн байлаа. Түүнчлэн умар зүгийн Шамбалын орноо Догшин хүрдэт хаан болох цагт өглөгийн эздээр Богд гэгээний нөхрийн манлай болон төрөхийг хүсэж дүйнхэрийн чогын ван хэмээх абшиг хайрлахыг гуйсныг ёсоор болгож Шамбалын оронд төрөх ерөөлийг зохиож хайрлажээ.

Жич, Чингис эзний хөргийг бүтээлгэж түүний нөхөр сэлт цогцсын зүрхэн Хутагтай Сэцэн хунтайж, Цагаан Эрх сэцэн хунтайж гурвууулыг эрхшүүлэн шүтэх зан үйлийн онол, заллага тахилга, хангал наминчлал, сан магтаал, даатгал дуртгал зэрэг маш дэлгэрэнгүй зүйлсийг зохиолгож аваад Банчон Богдоор амилуулж авснаар барахгүй бурхан шүтээн адистэд жанлав зангиа набчи, аяганы гэр, үнэрт хүж сэлтэс хайрласныг хүртээд Лхас руу баяртай эгжээ. /13/

Сүсэгтэн олон Лхаст буцсаны хойно Далай ламын гэгээн ба Галдан Дива Номун хан Доржчанжамъяншадав тэргүүтэн ихэс лам нараас ван, жинэн, лүн зэрэг олон адистэдийг хүртээд хар мичин жил (1812)-ийн хаврын сүүл сард нутаг буцах болов. Явахаас урьд Далай ламд бараалхвал Тодой туслагчийг өндөр суудалд саатуулан цай боорцог, жимсээр зочлоод настны рилү, үнэрт хүж, адист зангиа, magna дээл, бүс мутрын эрхи, чанма тэргүүтнийг хайрлаж, замдаа саад барцадгүй энх амгалан явж харихыг зөгнөн залбирсан ажгуу.

Эрх Дугар мэргэн ахай ноён санасан хэргээн бүтээгээд гэдрэг буцаж Гүнбүм хийд хүрэх үе зуны сар дуусаж, намрын сар орсон бөгөөд ноёны дүү хамба, лхаарамба, буяны садан хамба Даржэйжалсан, жич төрлийн тайж албат нар унаа хөсөг бэлтгэн тэдний хүрч ирэхийг хүлээн сууж байх нь тааралдаад бөөн баяр болсныг хэлэх газаргүй. Тэд нар Гүмбүм хийдийн ихэс лам нарт мөргөл үйлдээд нутгийн зүг аяны жолоог залбал замын гудаст бэйс ноён Буянтай болон лам нарын зарсан угтуулын улс учирч эхэлсэн тул хөнгөн унаатай цөөн хүмүүсийг яаралтай буцааж, засаг ноён болон төрөл садан олны амрыг асууж эсэн мэнд буцаж яваа, баярын мэдээг хүргүүлэхээр довтолгожээ.

Гүмбүм хийдээс Алашааг дайран тэндээс Ордос орох замд дээрэм тонуулгүй, тайван амгалан байсан тул мөргөлчдийн санаа амарч, эсэн мэнд гэрийн бараа харах боллоо, хэмээн олзуурхаж эхэлжээ. Эрх Дугар мэргэн ахай ноён Тодой туслагч, гэрээс гарсан цагаас хойш буцаж ирэх болтол дөрвөн улирал хэдийнээ улиран жил хагас болсон тул засаг бэйл Буянтай ван болон ураг саднаан санагалзаж, Урадын мэргэн гэгээнийг дуурайж, Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын “Найман арслант” хэмээх гүр дууны Ордос хувилбар болох “Найман гүн арслан” гэдэг дууг гаргажээ. Энэ хувилбарт:

01 Найман гүн арслант тавцангийн дээр

Навчит зандан мод бурханы чимэг

Нарны гэрлээр мандлаа шүү

02 Дөрвөн гүн арслант тавцангийн дээр

Дэгтэрт зандан мод бурханы чимэг

Сарны гэрлээр мандлаа шүү

03 Хаврын гурван арын салхин юу ихт

Хайрт төрөл маань газрын холд

Ашдын амар мэндийг асуун ерөөе дээ

04 Зуны гурван арын халуун юу ихт

Журамт төрөл маань газрын холд

Дахилт:

05 Намрын гурван сарын усны ихт

Найрамт төрөл маань газрын холд

Дахилт:

06 Өвлийн гурван сарын хүйтэн юу ихт

Ерөөлт төрөл мааньт газрын холд

Дахилт: 14

07 Тасын таван сард тасдаан чимэг шүү

Тамгын таван түшмэл ноёндон зэмсэг шүү

Дахилт:

08 Тогосын таван сөд тогосдоон чимэг шүү

Тамгын таван түшмэл ноёндон зэмсэг шүү

Дахилт:

09 Зуугийнхаа энэ холд зориглож л суулаа

Зуугийн бурханд даатгаж мөргөлөө


Дахилт:

10 Зуугийн зандан модонд зүйлийн шувуухай жиргэнэ

Зуугийн энэ орноос Шинсэ гэгээн ивээлээ

Дахилт: хэмээн дуусан байжээ.

Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын “Найман арслант” гэх гүр дууны бас нэгэн шинэчилсэн хувилбар нь Алагшаа хошууд хошууны шастир дуу “Найман арслант” болно. Энэхүү хувилбар нь Ордосын Сэцэн зоригт Эрх Дугар мэргэн ахай ноён Тодой туслагчийн шинэчилсэн эхийн суурин дээр зохиогдсон байна.



Тодой туслагчийн байгуулсан Дүйнхэрийн дацан ЗУРАГ№1

Сэцэн зоригт Дугар мэргэн ахай ноён хэмээх Тодой туслагч Төр Гэрэлтийн 9-р (1829) онд, Ордосын баруун гарын өмнөд хошууны шүтээний орон Ганжуур Номун хийд (Үүшин Зуу) дэх Дүйнхүрийн дацан.

Хэлбэрийн хувьд төдийлөн өөрчлөгдөөгүй хэдий ч Манжийн төрд шударга, үүрд хүндтэй байхыг бэлгэдсэн санаа нэвт шингэсэн төдийгүй эзэн төрийн төлөө эрэлхэг тэмцдэг баатар эрчүүдээрээ бахархах хүсэл, Алашаа вангийн онцгой байр сууриа эрхэмлэхийг, урт удаан он жилүүдийн турш жаргал цэнгэлтэй явах хүслээ зөгнөн бэлгэдсэн шинжтэй болсон байна. Уг дуунд:

01 Найман арслант тавцангийн дээд

Найрт эзэд маань төрдөөн баттай

Ашидын амар мэндээр жаргана ээ лэ зээ

02 Хаврын гурван сарын өдөртөөн салхитай

Хайрт эзэд маань төрдөөн баттай

Дахилт:

03 Зуны гурван сарын өдөртөөн халуунтай

Журамт эзэд маань төрдөөн баттай

Дахилт:

04 Намрын гурван сарын өдөртөөн сэрүүнтэй

Найрт эзэд маань төрдөөн баттай

Дахилт:

05 Өвлийн гурван сарын өдөртөөн хүйтэнтэй

Өршөөлт эзэд маань төрдөөн баттай

Дахилт:

06 Гурван хөөрийгөөн хээрийгээ чөдөртөөн дасгаж

Гурван баатрыгаан дайнд дасгаж

Дахилт:

07 Дөрвөн хөөрийгөөн чөдөртөөн дасгаж

Дөрвөн баатрыгаан дайнд дасгаж

Дахилт: гэж дуулдаг байна.

Чин сүжигт Номун хан Лувсаннорошаравын “Найман арслант” хэмээх гүр дууны шад, бадаг шүлгийг нягталж үзвэл намуун дөлгөөн, уужуу тайван, хэмнэл бүхий ухаарал баясалгалын өнгө аястай байсан нь тодорхой байна. Бичгийн хэлний загвар дээр зохиогдсон тэдгээр сонгодог бадгийг уртлаг хэмнэл бүхий нам дөлгөөн татлагаар дуулахгүй бол аялгуу эгшигийн цаламд багтааж үл чадна. Уг дуу дайн дажны хөл татарсан, цаг төр тайван амгалан болж, хамаг амьтад шашин ном тийш хошууран залбирч, сүсэглэж дээдэлж эхэлсэн цаг үе дэх сэргээж сэнхрүүлэхийг зорьсон хийсвэр сэтгэлгээний дүрслэмж бүхий бүтээл учраас амгалан тайван, бясалгалын агаар төгс нэвчсэн болох нь илт ажээ.

Өвөрлөгч нутаг дахь уг дууны хувилбаруудын шүлгийн бүтэц, ая данг ажиглавал нэлээд бэсрэгжсэн, цоглог шинжтэй болгож өөрчилсөн нь тамгын баяр, залуусын хурим найр, зэрэг жинс нэмэгдсэн баяр зэргийг тэмдэглэх ёслолын үед зориулагдсан болов уу гэмээр санагдаж байна.

Урад, Ордос, Алашаа нутаг дахь уг дууг дуулах хэв намба нэлээд зөрөөтэй байсан төдийгүй эл хошууны дуулах өнгө аяс нь харилцан адилгүй байсан бөгөөд

эдүгээ ч мөн тодорхой төвшинд өөрчлөгдсөөр байгаа гэдгийг ч хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болов уу.

2012 оны өвлийн сүүл сар Алагшаа нутгийн ардын дуучин Ло. Бадамаа гуай, туурвигчид “Алашаа нутгийн “Найман арслант” гэх дуу одоо зэргэлдээ орших Мин, чин, шианы иргэдийн нөлөөгөөр өг тог гэсэн цохилготой, дэн дан гэж гэнгэнэж гунганасан хөг аятай болж байна шүү. Уг нь ийм байгаагүй юм. “хэмээн харамсан ярьж байсан нь дээрхийн гэрч болох юм.

Чин сүжигт Номун хан Лувсанноровшаравын гүр дуу “Найман арслант”-ын хэмнэл хэсэг ч хөг аялгуу нь бэсрэгжиж бясалгал бодролын, шад, бадаг нь улс төрийн сурталчилгааны аястай болж хувирсан хэдий ч Мэргэн гэгээний шинэчилсэн Урад хувилбар болон Тодой туслагчийн гаргасан Ордос хувилбарт шашны оройн чимэг болсон ихэс лам нарыг бишрэн хүндэтгэж, жигүүртэн шувуу хүрэхгүй зайны газарт залбиран сууж, сүсэглэн мөргөх ёстой гэсэн гол санаа нь үндсэндээ хадгалагдсаар байгаад олдуурхаж байна.

Энэхүү гүр дуу нүүдэлчиний амьдралыг сүсэг бишрэлтэй нь холбон өгч улмаар дөрвөн улирлын байгалийн сонин сайхантай зэрэгцүүлж бадагласан нь уламжлалт монгол сэтгэлгээний онцлогийг бүрэн илэрхийлсэн байна.

SUMMARY

The version of the religious song ‘Naiman arslant’ /Eight lions/ has been still singing in Ordos Ikh-Zuu, Urad and Alagshaa. This song connects the nomadic people’s life to religion and worship. Marvel of four seasons in stanza expresses completely the features of Mongolians’ way of thinking.

НОМЗҮЙ

1. “Алашаа ардын дуу” Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 1988
2. С. Галлуу. “Монголоор дэлгэрсэн бурхан шашины ном соёл урлагийн түүх” Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 2003
3. У. Загдсүрэн. “Монгол дууны судлалын товч тойм” УБ. 1975
4. Н. Нарангэрэл. “Чин сүжигт Номун хааны өв соёл” УБ. 2011
5. С. Нарсун. Хэйрүвжунай “Богд гэгээн Үүшин Зуу хийд” Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 2008
6. “Өвөрмонголын аман үлгэрийн чуулган”- “Алашаа баруун хошууны боть” Өвөрмонголын Ардын хэвлэлийн хороо. 2007